

Монголын хэвлэлийн гэрэл зургийн түүхэн хөгжил

Цэрэндоржийн Батбаатар 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Сэтгүүл зүйн тэнхимийн докторант, МГЗНХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга

Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2023-11-29

Засварласан - Revised:
2023-12-13

Хэвлэгдсэн - Published:
2023-12-26

inet.batbaatar@gmail.com

ORCID: [0009-0008-5046-5179](https://orcid.org/0009-0008-5046-5179)



© 2023, Author(s)

Хураангуй: Монголд хэвлэлийн гэрэл зураг хэдий үеэс үүсэж хөгжсөн, түүнийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ, хэрхэн хөгжиж ирсэн чиг хандлага, одоогийн нөхцөл байдлын талаар товч авч үзэх юм. Монголд анх гэрэл зураг хөгжсөн нь хэвлэл мэдээллийн гэрэл зураг, гэрэл зургийн сэтгүүл зүй хөгжих үндэс болсон бөгөөд үндэсний гэрэл зургийн сэтгүүлчид төрж, мэргэжлийн төвшинд хөгжүүлэх талаар төр, засгаас авч хэрэгжүүлсэн олон талт арга хэмжээний үр дүнд тусгайлсан мэргэжлийн гэрэл зургийн сэтгүүлчдийг гадаадын их, дээд сургуульд сургаж, дээд боловсрол эзэмшүүлж байжээ. Фото сэтгүүл зүйд залуу үе түрэн гарч ирэхийн зэрэгцээ тодорхой төрөл, сэдэв, чиглэлүүдээр дагнасан сайн дурын клуб, бүлэг, нийгэмлэг, агентлаг болон ажиллаж байгаа нь гэрэл зургийн сэтгүүл зүйн хөгжлийн мөн нэгэн хэлбэр гэж болно. Өдөр тутмын сонин, сэтгүүлүүд болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрийн редакцадаа /зарим нь редакцтай эсэхэд эргэлзээтэй/ гэрэл зургийн редактор байтугай сурвалжлагч, гэрэл зурагчингүй ажилладаг. Олонх нь интернэтээс зургаа авч байгаа нь энэ цагийн гэрэл зургийн сэтгүүл зүйн хөгжилд ухралт болдог. Гэвч хөгжил дэвшилд дамжих, туулах ёстой “тийм” цаг үе, зүй тогтол гэж бий гэдэг. Цаашид бид гэрэл зургийн сэтгүүл зүйн хөгжлийг үечилж, тухайн үеийн байдал, өнөөгийн төвшинд хүрэхэд хэрхэн нөлөөлсөн талаар нарийвчлан судлах хэрэгцээ энэ салбарт бий.

Түлхүүр үг: Фото сэтгүүл зүй, түүхэн фото, фото зургийн хөгжил

Дэлхий дахинд гэрэл зургийн сэтгүүл зүй үүссэн тухай товчхон оршил

Дэлхийн гэрэл зургийн сэтгүүл зүй буюу фото сэтгүүл зүйг олон улсын судлаач эрдэмтэд үзэхдээ, *Үндэсний газар зүй сэтгүүл* 1903 онд анх гэрэл зурагтай дугаар хэвлүүлсэн. 1910 оноос эл байдал улам бүр эрчимжиж өнгөт зураг хэвлүүлж эхэлсэн тэр үеийг фото сэтгүүл зүйн үүсэл хэмээн судлаачид үздэг юм байна.

1942 онд сэтгүүл зүйн багш Френк Лютер Матт “фото сэтгүүл зүй” хэмээх нэр томъёог анх хэрэглэжээ (Норовсүрэн, 2012: 21). Френк Лютер Матт: Хэвлэлд мэргэжлийн гэрэл зургийн ач холбогдлыг анх удаа шинжлэх ухааны үндэстэй гаргаж тавьснаар мэдээ, мэдээлэлд гэрэл зургийн үр нөлөө, үүрэг, ач холбогдол ямар чухал болохыг нотлон харуулсан нь “сэтгүүл зүй”-д түүний оруулсан хувь нэмэр болсон юм. Тэр үеэс эхлэн фото сэтгүүлчид ур чадвар, билгийн хараа, эв дүйгээс гадна өөр олон чадвар эзэмшсэн байх ёстойг хэвлэл мэдээллийнхэн бүрэн хүлээн зөвшөөрч, мэргэшлийн төвшин ахин гэрэл зураг авах арга ухааныг их сургуульд буюу академик арга зүйгээр судалж эхэлсэн нь ихээхэн ахиц дэвшил болсон юм.

Лайф сэтгүүлийн редактораар ажиллаж байсан У.Хикс *Үгс ба зургууд* гэдэг номдоо “...үг, зураг хоёрыг ашиглан тухайн цаг мөчид юу болсныг хүмүүст ойлгогдохуйц байдлаар харахуйн хэлбэрт оруулан тайлбарлахыг фото сэтгүүл зүй” (Lewis, 1995: 7) гэж тодорхойлжээ.

Монголчууд гэрэл зурагтай танилцсан тухай

Харин Монголд фото сэтгүүл зүй буюу хэвлэлийн гэрэл зураг хэдийд үүссэн талаар холбогдох тодорхой баримтууд байдаг. 1873-1925 оны хооронд Монгол орноор гадаадын 200-300 орчим эрдэмтэн, судлаач, аялагч явсан тухай түүхэн фото баримтууд нэлээд бий. Орос, Герман, Франц, Америк, Дани, Япон, Хятад зэрэг олон орны аялагч, судлаачид Монгол орны бодит дүр төрхийг гэрэл зурагт буулган дэлхий нийтэд түгээн таниулж байжээ. Мөн тэр үеэс монголчууд гэрэл зургийн гайхамшигийг мэдэрч эхэлжээ. Монгол орны тухай анхны гэрэл зургуудыг Хаант Оросын судлаачид болох А.Н.Боярский, С.М.Дудин, А.В.Адрианов, Н.А.Чарушин, В.В.Ланин нар авсан байдаг. Тэдгээр нь Монголчуудын тухай нэгэн үеийн түүхийг гэрэл зургаар үзүүлсэн ховор баримт юм.

Түүний дотроос богд хаан, эх дагина хоёрын хамт авхуулсан бүтэн биеийн хөрөг, Богд хаант Монгол Улсаас Хаант Орос улсад суух Элчин сайд, Сайн ноён хан Намнансүрэн итгэмжлэх жуух бичгээ барьж буй зэрэг зургууд манай гэрэл зургийн анхны хэвлэлд нийтлэгдсэн бүтээлүүдийн тоонд ордог байна (Норовсүрэн, 2012: 8). Монголын төлөөлөгчид Петербург хотноо айлчилсан зургийг Оросын гэрэл зурагчин Б.К.Була авч *Дэлхий даяар* гэх сэтгүүлд 1912 онд хэвлүүлж байжээ. Тэдгээр зургийг

өнөөгийн бид одоо хараад ихийг ойлгоход үнэлж баршгүй хувь нэмэр болдог төдийгүй түүхэн эх сурвалж болдог судалгааны эргэлтэд орж байна.

Монгол хүмүүсийн зураг тогтмол хэвлэлд нийтлэгдсэн үе ч мөн л өнгөрсөн зууны арваад онд холбогдох юм. XIX зууны сүүлч, XX зууны эхэн үед гадаад улс орнуудаас Монголд зориулан гаргаж байсан хэвлэлүүдэд хэсэгчилсэн болон ганцаарчилсан хөрөг зургууд нийтлэгдэж байсан нь хожмоо монголын сэтгүүл зүйн фото нийтлэлийн үндэс суурь болжээ хэмээн тодорхойлж болохоор байна.

Тухайлбал: “...1911 оны наймдугаар сараас 1914 оны есдүгээр сар хүртэл Бээжинд сар болгон гаргаж байсан *Монгол ер үгийн сэтгүүл* нь зураг зурмал, цааз зарлал, шүүмжлэл өгүүлэл, чухал сонсгол, өчих асуух, албан бичиг, тусгай зүйл, бага үлгэр гэсэн булангуудтай байв. Сэтгүүлийн зураг зурмалын буланд Монгол-Хятадын харилцаанд холбогдол бүхий хэрэг явдлын тухай нийтэлж байв. Жишээлбэл, монголчуудын суралцдаг сургуулийн дарга даамлын зураг, Бээжингийн хязгаар болох тэргүүн зэргийн сургуулийн улаан, хөх жинстний ангийг төгсөгчдийн зураг сэлт гарч байсан” (Норовсүрэн, 2012: 50) байна.

Басхүү “1909 оны тавдугаар сараас 1918 оны арван хоёрдугаар сар хүртэл Харбин хот дахь Дорнод Хятадын төмөр замын Оросын захиргаанаас эрхлэн сард хоёр удаа гаргаж байсан *Монгол сонин бичиг* нь өөрийн байнгын сурвалжлагчдыг Монголын Да Хүрээ, Улиастай, Ховд, Хөлөнбуйр зэрэг хүн ам төвлөрсөн сууринуудад ажиллуулж байв. Тус сонин 1917 оны 10 дугаар сард Нийслэл хүрээнд сурвалжлах товчоо байгуулж, уг товчоонд ажиллах хүмүүст сар тутам 30 төгрөгийн цалин олгож бас цахилгаан утас, гэрэл зургийн зардлыг нэмэн өгч” (Дэлэг, 1965: 18-19) байжээ. Уг сонины нийтлэлд гар болон гэрэл зураг тодорхой байртай байв.

Түүнчлэн VIII Богд Жавзандамба хутагтын дэргэд 1904 оны орчмоос хятад зурагчин сууж ажилладаг болсон тухай түүхийн баримтад тэмдэглэжээ. 1911 онд Монгол Улс тусгаар тогтносны дараа Богд хааны ордонд Дамбадаржаа зурагчнаар, Ванпилов хэмээх Бадам жолооч бөгөөд кино механикчаар ажиллаж байсан тухай баримт ч бий. Эдгээрээс гадна манай орноор аялан явсан эрдэмтэн, жуулчин мөн худалдаачид монголчуудын амьдралыг гэрэл зургаар сурталчилсан анхдагчид мөн.

Харбин хотод хэвлэгдэж байсан *Монгол сонин бичиг* сонинд цаг үеийн дэлгэрэнгүй болон товч мэдээ, шог өгүүлэл, ярилцаа, мэдээлэл, тэмдэглэлт шүүмжлэлт, өгүүлэл, гадаадын мэдээ, худалдааны зар, гэрэл зураг, гар зургууд нийтлэгдэж байсан (Дэлэг, 1965) тухай судлаачид тэмдэглэсэн байна.

Харин Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын үед Бадам, Хэмжээт цаазат Монгол улсын үед Судар бичгийн хүрээлэнгийн зурагчин байсан Чойжинням нарын зэрэг цөөн тооны монгол хүн зураг авч байсан бөгөөд гадаадын эрдэмтэд, Монголыг

судлагчид, жуулчид тэр үеийн монголын нүүр царай, аж амьдралыг гэрэл зурагт буулгаж үлдээжээ (Баасансүрэн, 1985: 6).

Хэвлэлийн хуудаст анх гарсан гэрэл зургийн хувьд гэвэл *Монгол ардын үндэсний соёлын зам* сэтгүүлийн 1924 оны наймдугаар сарын дугаарт “Ардын засаг Нийслэл Хүрээг тогтоогоод байсан үе. Нөхөр Сүхбаатар, Бодоо, Данзан, Япон Данзан Элбэгдорж нар баймой” гэсэн нэртэй зураг хэвлэгдсэн байдаг нь анхны зураг гэж тооцогдож байна. Ер нь монгол улсын хувьд анхны гэрэл зургууд нь хувьсгалын удирдагчдын хөрөг маягийн зургууд байсан нь дээрх баримтуудаас харагддаг. Энэ бүгдээс харахад тэр үеийн сонин, сэтгүүлд зөвхөн хөрөг маягийн зураг л нийтэлж байсан нь ажиглагдана.

Монголд гэрэл зургийн сэтгүүл зүй үүсэх нөхцөл бүрдсэн нь

1920-иод он буюу Ардын хувьсгал ялснаас хойш Монгол оронд 1930 оны дунд үеэс эхлэн гэрэл зургийн газар албан ёсоор байгуулагдаж, төр засгаас энэ талд тусгайлан анхаарах болсноор гэрэл зураг нь сэтгүүл зүйн бие даасан нэгэн төрөл болж, төлөвшиж эхэлсэн гэж үзэж болох юм. Тухайн үеийн *Үнэн*, *Ардын үндэсний эрх*, *Улаан од* зэрэг хэвлэлүүдэд Б.Чойжинням, Ц.Дагдандорж, М.Гомбажав зэрэг манай анхдагч болох гэрэл зурагчдын авсан гэрэл зураг, фото мэдээ, сурвалжилга, хөрөг тогтмол гарах болжээ. 1970-аад он гэхэд гэрэл зургийн сэтгүүл зүй нэгэнт өнгө төрхөө бүрэн олж, төрөл зүйл нь жигдрэн хөгжиж, мэргэжлийн сэтгүүлчдийг бэлтгэж эхэлсэн байна.

Сонин, сэтгүүлийн гэрэл зургийг сайжруулах, гэрэл зурагчдын ажлыг нэгдмэл ажиллагаагаар хангахын тулд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1956 оны зургаадугаар сарын 9-ний 170 дугаар тогтоолоор “Сонин, сэтгүүлийн фото зурагчдыг нэгтгэх тухай” (Норовсүрэн, 1982: 59) шийдвэрийг гаргаж, төсөв, журмыг баталсан байдаг.

Уг журамд зааснаар *Хөдөлмөр*, *Залуучууд*, *Улаанбаатарын мэдээ*, *Үнэн сонин*, *Туяа* сэтгүүлийн зурагчдыг нэгтгэж монголын сонин, сэтгүүлийн дэргэд фото сурвалжлагчдын товчоо ажиллахаар зааж, товчооны бүрэлдэхүүнд ахлагч-1, зурагчин-4, зурагчин тус бүр сар тутам 750 төгрөг, ахлагч 800 төгрөгийн цалинтай байх, сар тутам гарах сонин, хоёр сар тутам гарах орос хэл дээр гарах сэтгүүл зэрэгт бүгд 66 удаагийн сонинд 143 зураг бэлтгэн өгч байхаар үүргийг нь тодорхойлжээ.

Энэ тогтоолын нэг ач холбогдол нь Монголын түүхэнд холбогдох гэрэл зургуудаас шилдэг сайн 20 зургийг сар бүр Зөвлөлтийн ТАСС-ын газар ба ардын ардчилсан орнуудад шилдэг зургуудаасаа явуулах болсон нь Монгол улсыг сурталчлахад гол үүрэг гүйцэтгэх болжээ.

Монголд гэрэл зургийн сэтгүүлчидтэй болсон нь

Үндэсний хэмжээнд 1940 оны дунд үеэс фото зураг мэдээллийн хэрэгсэл сэтгүүл зүйн үйл ажиллагааны төрөл болох чиглэлээр дагнан хөгжиж, тэр цагаас хойш өдөр тутмын “Үнэн” сонины анхдагч болох фоточин Ц.Дагдандорж, Н.Оцол, Ж.Найдан, Б.Лувсанжамц нараас хойш мэргэжлийн фото сэтгүүлчид М.Лхагвасүрэн, С.Туяа, М.Цэрэнжамц, Р.Чулуун, Н.Бөхдамбий, Т.Дамбадаржаа нарыг залгамжлан гадаадад дээд мэргэжил эзэмшсэн фото сэтгүүлч Р.Энхбат, С.Цацралт, Т.Өсөхбаатар нар ажиллах болсноор гэрэл зургийн өнгө төрх, өгүүлэм, зохиомжид эрс өөрчлөлт шинэчлэл болсон хэмээн үзэж болно.

Хөдөлмөр сонинд Ч.Лосол, Х.Чүлтэм, Ж.Чойжоо, Г.Ичин, Дамчаабадгар, Ч.Намхай, Л.Туяа, Н.Пүрэвдаш, *Залуучуудын үнэн* сонинд Ц.Агваанрэнцэн, Л.Болд, Б.Чантуу, С.Лувсаншагдар, Д.Пушкин, *Пионерийн үнэн* сонинд Н.Дорж, С.Бодоош, *Улаанбаатар мэдээ* сонинд С.Сампилноров, Д.Эрдэнэ-Очир, *Орчин үеийн Монгол* сэтгүүлд Б.Сүхээ, Д.Бүрнээбаатар, Д.Нямхүү, Д.Сосоржав, Л.Санжмятав, Р.Гомбожав, *Шинжлэх ухаан амьдрал* сэтгүүлд Давагсамбуу, *Утга зохиол урлаг* сонинд Ш.Сайханбаяр, Дугаржавын Цэрэннадмид /эмэгтэй/, *Улаан од* сонинд Ө.Сэнгээ, Б.Батаа, Жаргалсайхан, Дашдорж, Баярсайхан, *Эх орны манаа* сонинд Цэнджав, Улсын гэрэл зураг болон МОНЦАМЭ агентлагт Б.Сүхээ, Л.Санжмятав, Ичинноров, Д.Дэлэгням, Ц.Дарьсүрэн, И.Чулуун, Б.Улияатайхүү, Д.Норовдорж, Рэнцэндорж, Ц.Нина, Д.Самдан, С.Батсүх нарын зэрэг хүмүүс фото сэтгүүлч, гэрэл зургийн сурвалжлагчаар олон жил ажиллаж бүтээл нь тухай, тухайн сонин хэвлэлд тод үлджээ.

1980-1990-ээд оны сонин хэвлэлийн гэрэл зурагчдын төлөөлөл болох М.Лхагвасүрэн, Р.Энхбат, С.Цацралт, Ц.Батзориг, Т.Өсөхбаатар, Н.Гончигсүрэн, В.Баттулга, Э.Эрдэнэбаяр, Ү.Ганбаяр зэрэг үе үеийн гэрэл зурагчдын уран бүтээлээс нь түгээн дэлгэрүүлж сурталчилж, гэрэл зургийн хөгжлийн бодит түүхийг тоймлон гаргахад судлаачид ихээхэн үүрэг гүйцэтгэж байна.

Монголын гэрэл зургийн сэтгүүл зүйн хөгжлийг үечлэх асуудалд

Энэ удаагийн судалгаагаар монголын гэрэл зургийн хөгжил тэр дундаа фото сэтгүүл зүйн түүхийг тодорхой байдлаар үечлэхийг зорив.

Ингэхдээ бид он цагийн баримжааг харгалзахын зэрэгцээ манайд гэрэл зургийн хөгжлийн ерөнхий байдал, хандлага, хувьсал өөрчлөлт, төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг харгалзан үзэж үечлэл хийхийг зорьсон болно. Үүнд:

- Монголд гэрэл зургийн сэтгүүл зүй үүссэн эхэн үе. 1940-1960-аад оны эхэн үе;
- Монголын мэргэшсэн гэрэл зургийн сэтгүүл зүй, төлөвшсөн үе. 1960-1980-аад он хүртэл;

- Монголын дээд мэргэжлийн гэрэл зургийн сэтгүүл зүй хөгжсөн үе. 1980-1990 он хүртэл;
- Зах зээл, нийгмийн шилжилтийн гэрэл зургийн сэтгүүл зүйн үе. 1990-2010 он;
- Ардчилсан нийгмийн үеийн гэрэл зургийн сэтгүүл зүйн үе. 2011 оноос өнөө хүртэл хойш *Цахим буюу орчин цагийн фото сэтгүүл зүй* гэж тав хуваан үзэж болохоор байна.

Ийм үечлэлийг хийхдээ бид гэрэл зургийн техник технологийн хөгжлөөс гадна мэргэжлийн гэрэл зурагчид бий болж, өсөж торнисон мэргэжиж боловсорсон үеийг харгалзуулан авч үзэв.

Монголд гэрэл зургийн сэтгүүл зүй үүссэн эхэн үе. 1940-1960-аад он

Монголд фото сэтгүүл зүйг хөгжүүлэхэд 1940-өөд оноос эхлэн Улсын гэрэл зургийн газар, Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг онцгой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэдний сэтгүүлчдийн бүтээлүүд олны хүртээл болж, мэргэжлийн гэрэл зурагчид, фото сэтгүүлчид олноор тодрон гарсан байна.

Энэ үеийн гэрэл зургийн хөгжил, дэвшлийг *Үнэн* сонинтой холбож үздэг ба гэрэл зургийн сэтгүүлчдийн олонх нь энэ сониныг дамжиж гарсан байдаг. 1940-1950-аад оны эхээс *Үнэн* сонинд Ц.Дагдандорж, Н.Оцол, Ж.Найдан, Б.Лувсанжамц нарын ахмадууд ажиллаж эхэлснээр сонины мэргэшсэн гэрэл зурагчид бий болох эхлэлийг тавьсан хэмээн үзэж болох юм.

Монголын сэтгүүл зүйн үр нөлөөтэй чиглэлийн нэг болох фото сэтгүүл зүйг хөгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн анхдагчдын нэг нь Цэнд-Аюушийн Дагдандорж мөн. Монголын ууган зурагчдын нэг Б.Чойжинням түүнд гэрэл зургийн анхны эрдмийг зааж чиглүүлсэн байдаг. Ц.Дагдандоржид мөн 1940 оноос Зөвлөлтийн мэргэжилтэн Е.И.Колонин гэдэг хүн фото зааж байсан аж. Тэрбээр 1950-аад оноос *Туяа* сэтгүүлд фото сурвалжлагч, 1952 оноос *Үнэн* сонинд фото сурвалжлагч, тасгийн эрхлэгч зэрэг ажлыг хорь шахам жил хийж байгаад 1968 онд тэтгэвэртээ гарсан байна. Ц.Дагдандорж Монголын ахмад гэрэл зурагчны хувьд 1940-1960 оны хооронд улс орны амьдралд тохиолдсон нийгэм, улс төр, бүтээн байгуулалтын томоохон үйл явдлуудыг гэрэл зурагт мөнхжүүлсэн гавьяатай уран бүтээлч юм (Норовсүрэн, 2012: 62).

Энэ нь монголын гэрэл зургийн хөгжлийг бодитой хөгжүүлэхэд төр, засгаас тууштай бодлого баримталж эхэлсэн, мэргэжлийн гэрэл зурагчдыг бэлтгэхэд ихээхэн хүч, анхаарал тавьсан, бие даасан хөгжлийн гараанд ирсэн чухал, түүхэн үе мөн.

Монголын мэргэшсэн гэрэл зургийн сэтгүүл зүй үүсэж, төлөвшсөн үе. 1960-1970-аад оны төгсгөл хүртэл

1957 оноос төр засгийн шийдвэрээр Улсын гэрэл зургийн газрыг байгуулсан нь бие даасан мэргэжлийн гэрэл зургийн сэтгүүлчид төрж гарах, үндэсний боловсон хүчнийг бодлогоор бэлтгэж, үндэсний гэрэл зургийн сэтгүүл зүйг хөгжүүлэх боломжийг нээж өгчээ. 1960-аад онд төвийн сонин хэвлэлд гэрэл зураг голлох байрыг эзэлж, мэргэжлийн гэрэл зурагчид төрж, сэтгүүл зүйн салбарт дагнан ажилладаг хүмүүс бий болсон нь гэрэл зургийн хөгжлийг түргэтгэсэн байна.

1970-аад оноос хойш мэргэжлийн гэрэл зургийн сэтгүүлчдийг бэлтгэх, мэргэшүүлэх олон талт ажил хийж эхэлсний үр дүнд 1972 онд ЗХУ-ын Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их сургуулийг фото сэтгүүлчийн анхны мэргэжлийн хүн болж М.Лхагвасүрэн онц дүнтэй төгсөж ирсэн нь гэрэл зургийн салбарт гарсан хөгжил ололтын нэг байжээ. Мэргэжлийн фото сэтгүүлчид бэлтгэхээр социалист нийгмийн үед улсын бодлогоор ЗХУ, БНАГУ зэрэг оронд бодлогоор явуулж бэлтгэгдсэн мэргэжлийн фото сэтгүүлчид ажиллах болж, өөрийн орны сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт гэрэл зургийн сэтгүүл зүйн хичээлийг хөтөлбөрт нь оруулан заадаг болсон нь гэрэл зургийн сэтгүүлчдийн эгнээг өргөтгөж ур чадварыг ахиулахад чухал түлхэц болсон. Тэр үед БНАГУ-д фото сэтгүүлчдээр цөөнгүй боловсон хүчин бэлтгэсэн байдаг юм. Тэдгээрээс Германы Лейпциг хотноо фото чиглэлээр дүүргэсэн дүүргэсэн С.Туяа, Р.Энхбат, Р.Гоцбаяр нарыг нэрлэж болно. Мөн ЗХУ-ын Москва, Ленинград, Эрхүү болон бусад хотуудад фото сэтгүүлчээр сурч төгссөн мэргэжлийн боловсон хүчнээр Монголын гэрэл зурагчдын эгнээг өргөжүүлсэн байдаг.

Дээхэн үеэс нэрт кино зураглаач, Төрийн шагналт О.Уртнасан, М.Лхагвасүрэн нарын дараа үед Б.Чантуу, М.Цэрэнжамц болон зарим манай ахмадууд суралцсан байгаа юм.

1980 оны үеийн гэрэл зурагчид болох ЗХУ-д С.Цацралт, Д.Мөнхжаргал, Ц.Батзориг, В.Баттулга, Д.Жаргалсайхан, Ө.Баттайван, Т.Өсөхбаатар, С.Бадамханд нарын зэрэг манай шилдэг фоточид мөн л гадаадад сурсан байна. Энэ л үеэс гэрэл зургийн хөгжилд технологийн хувьд ихээхэн дэвшил гарч, мэргэжлийн аппарат, техник хэрэгсэл сайжирч, төр засгаас тусгайлан дэмжиж, хөгжлийн бодлогыг нь тодорхойлж байв.

1979 онд Улсын гэрэл зургийн газар, МРТУХ-ны Гэрэл зургийн ерөнхий редакци хоёрыг нэгтгэж МРТУХ-ны харьяа Улсын гэрэл зургийн газар болгон өргөтгөж, манай улсын гэрэл зургийн гадаад, дотод сурталчилгааны бүх ажлыг энэ газарт хариуцуулсан байна.

Улсын гэрэл зургийн газрын үүрэг зорилго ийнхүү улам нарийн тодорхой болж, материаллаг бааз, боловсон хүчний хувьд ихээхэн бэхжиж ирсэн байдаг. 1980 он болоход тус газарт гадаад, дотоодын их дээд, дунд сургууль төгссөн мэргэжлийн

сэтгүүлчид, мэргэшсэн ажилчид ажиллаж тухайн үеийнхээ хамгийн өндөр хүчин чадалтай аппарат хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигладаг болсон байв.

Улсын гэрэл зургийн газар гадаад орнуудын мэдээллийн агентлагуудтай өдөр тутмын холбоотой ажиллаж, өөрийн орныг хилийн чанадад гэрэл зургаар сурталчилж байлаа. 1980-аад оны эцэс гэхэд Улсын гэрэл зургийн газарт түүхийн үнэт баримт болсон 80000 гаруй ховор чухал хальс хадгалагдаж, тэр нь жилээс жилд баяжиж байв.

Улсын гэрэл зургийн газрын зурагчид зөвхөн гадаад дотоод сурталчилгааны зураг авч, Монгол орны түүхийг бүрдүүлж архивлаад зогсохгүй, хэвлэл мэдээллийн хэрэгслийг цаг үеийн гэрэл зургийн мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж байлаа. М.Лхагвасүрэн, М.Цэрэнжамц, Б.Сүхээ, Д.Самдан, Ц.Нина, С.Батсүх, Р.Энхбат, С.Цацралт, Ц.Батзориг нарын шилдэг фоточдын бүтээлүүд төвийн тогтмол хэвлэлийн хуудсанд байнга гарч уншигч олны хүртээл болж, мэдээллийн чанар чансааг улам бүр баяжуулж байлаа.

Монгол Улсын мэргэжлийн гэрэл зурагчдын үе л яалт ч үгүй 1970 оны сүүл үеэс эхэлсэн гэж үзэж болно.

Үнэн сонины фото сурвалжлагчаас төр засгийн итгэмжлэгдсэн зурагчин хүртэлх нэр төртэй ажлыг нэр тэртэйгээр Магсарын Цэрэнжамц гүйцэтгэж явсан. Тэр бээр 1967 оноос 1995 он хүртэл өдөр тутмын хэвлэл *Үнэн*, *Ардын эрх* сонинд гэрэл зургийн сурвалжлагчаар ажиллаж байсан. Дэлхийн Сэтгүүлчдийн холбооны тэргүүн “Гран-При” шагналыг 1981 онд Монголын хэвлэл мэдээллийн салбараас анхлан хүртэж байсан бол удалгүй 1984 онд “Дэлхийн шилдэг 100 фотомастер”-ын нэгээр тодорч байжээ.

Дээр дурдсан хөгжлийн түүхийг нэгтгэн дүгнэвэл бие даасан мэргэжлийн гэрэл зурагчид төрөн гарсан, тэр дундаас мэргэжлийн гэрэл зургийн сэтгүүлчид ЗХУ болон гадаадын бусад оронд мэргэжил боловсрол эзэмшиж, техник технологийн хувьд хөгжлийн шинэ шатанд гарч, монголчууд гэрэл зургийг зүрх сэтгэлээрээ мэдэрдэг болж, фото сэтгүүл зүйн хөгжил батжин хөгжиж, боловсон хүчин, материаллаг баазын хувьд бэхэжсэн хөгжлийн үе байжээ.

Хэдийгээр социалист нийгмийн үед үзэл суртлын индэр байсан хэдий ч тухайн үеийн түүхийг гэрэл зурагт мөнхжүүлэн сонин, сэтгүүлийн хуудсанд баринтагласан нь өнөө үеийнхэнд үнэлж баршгүй үнэ цэнтэй баримт болжээ.

Ардчилсан нийгмийн үеийн гэрэл зургийн сэтгүүл зүй буюу 1990-2010 он

Энэ үед нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдсөнөөр сонин, хэвлэлийн салбарт ч өөрчлөлт шинэчлэл явагдаж хувийн хэвшил руу шилжиж эхэлсэн түүх одоо ч үргэлжилсээр байна.

1990 оны эхээр *Шинэ толь*, *Ардчилал* сонин А2-А3 форматаар 4 нүүр хэвлэж анхны чөлөөт сонин 100 мянган хувиар хэвлэгдэн гарснаар чөлөөт хэвлэлийн суурь тавигдсан гэж үздэг.

1993 оны наймдугаар сард гэрэл зургийн анхны сэтгүүл “Гэрэл сүүдэр” нэртэй гарч уг сэтгүүлд тэр үеийн шилдэг фото сэтгүүлчид Р.Энхбат, Ц.Батзориг, С.Цацралт нарын бүтээлүүд нийтлэгдэж, уншигч олны хүртээл болж байсан. Сэтгүүл ердөө нэг дугаар хэвлэсэн.

Өдөр тутмын анхны чөлөөт хэвлэл *МН-Өнөөдөр* сонин 1996 онд, гэрэл зураг мэдээллийн *Гамма* агентлаг мөн 1996 онд, *Фотомон* агентлаг 1998 онд байгуулагдсанаар хэвлэлийн гэрэл зурагт шинэ өнгө төрх орж ирсэн байх юм.

Эдгээрийг тодотгож буй нь тэнд гэрэл зургийн томоохон баг ажиллаж сонин хэвлэлд гэрэл зургийн өрсөлдөөнийг бий болгож байсан үе хэмээн үзэх болохоор байгаа юм. Тухайлбал Төрийн төв хэвлэл *Ардын эрх* сонин найм хүртэл хүнтэй алба байгуулж, *Өнөөдөр* сонин гэрэл зургийн албандаа анхаарснаар 5-6 фото сурвалжлагч ажиллуулах зэргээр сонины мэдээг сонирхолтой агшин, содон гэрэл зургуудаар тодосгон гаргаж эхэлсэн юм.

Энэ нь гэрэл зургийн эрчтэй, хүчтэй, нийтлэлийн өнгө төрхийг ихэд өөрчилсөн цаг хугацаа 2009 оноос цахим сэтгүүл зүйн хөгжилтэй холбогдож эхэлснээр харьцангуй эрч нь буурсан.

Монголын орчин үеийн хэвлэлийн гэрэл зургийн хөгжил шинэ ийнхүү цахим шилжилтийн үед орсноор хэт олширсон олон мэдээллийн хэрэгслүүд түүний дотроос мэдээний сайтууд гэрэл зургийн мэдээллийг шуурхай түгээж эхэлсэн. Харамсалтай энэ үеэс эхлэн гэрэл зургийг хянах, редакторлах шалгуургүй болж ямар ч хяналтгүй зургууд цацагдаж, зөвхөн мэдээллийн хурдаараа өрсөлдөх болсноор гэрэл зураг авч нийтлэх, цацах нь нэн хялбар ажил мэтээр ойлгоход хүрчээ. Боловсон хүчний асуудалдаа илүүтэй анхаарах шаардлагыг нэн тэргүүнд тавих цаг болжээ.

Цахим буюу орчин цагийн фото сэтгүүл зүйн үе. 2010-2023 он

2010-аад оноос хойш хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл буюу өдөр тутмын болон тодорхой давтамжаар хэвлэгддэг тогтмол хэвлэлүүдэд фото нийтлэлийн өнгө төрх харьцангуй буурч, үйл явдлын өгүүлэмжтэй зураг цөөхөн тоогоор нийтлэгдэж байв.

Харин сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гэрэл зургийн эзлэх байр суурь өсөн нэмэгдэж, сонин хэвлэлийн өнгө төрхийг чимж, уншигчдад гэрэл зургаар хүргэх мэдээллийн чанар нь өвөрмөц хэв шинжтэй байна.

Нийгмийн хөгжлийн болон техник технологийн өндөр хурд, уншигчдын амьдралын эрчим нэмэгдсэн, цахим ертөнцөд бүх зүйл шилжсэнтэй холбоотойгоор

хүмүүс уламжлалт унших аргаас татгалзаж харах, үзэх хэлбэрийг чухалчилж бага цагт их мэдээлэл авахыг эрхэмлэдэг болсон өнөө үед гэрэл зураг, зурагт хэвлэл, сэтгүүл, телевизээс шаардлагатай мэдээллээ шуурхай авахыг хичээх болжээ. Фото сэтгүүл зүй энд дурдаж буй эрэлт хэрэгцээг тодорхой хэмжээнд хангаж байна.

Фото сэтгүүл зүйд залуу үе түрэн орж ирэхийн зэрэгцээ тодорхой төрөл, сэдэв, чиглэлүүдээр дагнасан сайн дурын клуб, бүлэг, нийгэмлэг, агентлаг үүсэн бий болон ажиллаж байгаа нь гэрэл зургийн сэтгүүл зүйн хөгжлийн мөн нэгэн шинэлэг хэлбэр гэж болно.

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар: 2010 онд Монгол Улсын хэмжээнд байсан 383 мэдээллийн хэрэгслээс 88 хувь буюу 337 нь судалгаандаа хамруулахад хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах түгээмэл хэрэгслийн бүтцэд ихээхэн өөрчлөлт орж буй нь тодорхой харагдсан байна. Тухайлбал 1988 онд иргэдийн мэдээлэл авдаг гол суваг радио байсан бол 1999-2009 онд телевиз, сонин, радио гэсэн дарааллын араас интернэт орж ирсэн байна.

Энэ үед Монголын анхны мэдээллийн сайтуудын үйл ажиллагаа жигдэрч эхэлсэн бөгөөд Olloo.mn сайт 2007 онд анх удаа IPO хийж олон нийтэд хувьцаагаа гаргасан байна. 2010 оны хамгийн хүртээмжтэй таван сайтаар Gogo.mn, Olloo.mn, Zалуu.com, Banjig.net, News.mn сайтууд нэрлэгдэж байжээ.

Улмаар 2011-2013 оны хооронд сайтын тоо 30-71 болж нэмэгдэж байв. 2014 оны судалгаагаар 506 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тоологдсон ба энэ үед уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн төвлөрөлтэй зэрэгцэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиглалтын цагт өөрчлөлт орж, интернэт, социал медиа ашиглах нь эрс нэмэгджээ. Хэрэглэгчид интернэтийг өдөрт 1-4 цаг ашигладаг бол сонин, сэтгүүл, радиод 30 минутаас 1 цагийг зарцуулж байв.

Харин 2019 оны байдлаар Монголд 348 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тоологдов. Хэвлэл мэдээллийн бүх салбарт тоо нэмэгджээ. Сонины тоо 88-92, сэтгүүл 71-78, радио 48-50, телевиз 127-128, мэдээллийн сайт 100-109 болжээ. (Хүрээлэн, 2022: 25) Нийгмийн сүлжээ уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хэрэглэгчдэдээ хүрэх талбар болсон бөгөөд технологид суурилсан бусад аргуудыг ч мэдээлэл түгээхэд ашиглаж байна. Тухайлбал, дөрвөн сайт тутмын нэг нь лайвстрим мэдээ, мэдээллийг газар дээрээс нь хүргэх болов.

Мэдээллийн хэрэгсэл, сэтгүүл зүйн үндсэн үүрэг нэг талаас харахад олон нийтийн сүлжээнд иргэдийн оруулж буй олон янзын мэдээлэл, санал сэтгэгдэл, нийтлэл зэрэгт байр сууриа алдаж байгаа мэт харагдаж байж болох юм. Гэхдээ хашир, ул суурьтай уншигчид баталгаатай, эх сурвалжтай, итгэж болохуйц хэвлэлд ач холбогдол өгсөн хэвээр байна. Тэдгээр итгэж болох хэвлэлүүд нь гэрэл зургийн

үнэлэмж, ач холбогдлыг төдийлөн анхаарахгүй, орхигдуулаад байгаа нь ажиглагдаж байна.

Өдөр тутмын хэвлэлийн орон зайд сүүлийн арав орчим жил Гэрэл зургийн мэдээллийн МРА /Mongolian Press Agency/ агентлаг багагүй үүрэг гүйцэтгэж, хэвлэл мэдээллийн гэрэл зураг, шууд дамжуулалтыг мэргэжлийн төвшинд хамгийн дөхүү хэлбэрээр хийж хэрэгжүүлж байгаагаас гадна хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээллийн гэрэл зургийн бүх төрлийн бүтээгдэхүүнээр сурвалжилга бэлтгэн хүргүүлж байгаа юм.

Хэвлэл мэдээллийн гэрэл зураг, шууд дамжуулалтын МРА.mn агентлагийг гэрэл зурагчин Б.Бямба-Очир 2013 онд үүсгэн байгуулсан юм. Өдгөө гадаад, дотоодын 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагад гэрэл зургийн сурвалжилга бэлтгэн нийлүүлж байна. Тухайлбал, дотоодын ikon.mn, shuud.mn, Ubn.mn, zarig.mn, 24tsag.mn, newspress.mn, гадаадын AFP, Ройтерс зэрэг томоохон агентлагуудтай холбогдон ажиллаж байгааг дурдаж болно.

МРА нь 2013 онд зөвхөн хэвлэл мэдээллийн гэрэл зургаар дагнан үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2017 оноос шууд дамжуулалт буюу live бэлтгэн гэрээт сувгууддаа нийлүүлдэг болжээ. Эндээс гэрэл зургийн бас нэг дэвшил, хөгжлийг харж болно.

Дүгнэлт

Монголын гэрэл зургийн түүхэн хөгжлийн авч үзэхдээ үечилж, тухайн цаг үеийн хөгжлийн хандлагыг авч үзэх нь чухал гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Монголчууд хэдийгээр гэрэл зурагтай XIX зууны сүүлч, XX зууны эхэнд танилцсан хэдий боловч өөрсдийн үндэсний гэрэл зурагчидтай болох нөхцөл нь XX зууны 30-аад оноос тавигдсан болох нь харагдаж байна.

1930-аад оноос Гэрэл зургийн байгууллагын үүсэл тавигдаж, мэргэжлийн гэрэл зурагчдыг бий болох нөхцөл бүрдсэн болох нь түүхэн баримтаас харагдаж байгаа ч гэрэл зургийн сэтгүүл зүй бий болоход 1956 оны 170-р тогтоол чухал үүрэг гүйцэтгэсэн болох нь харагдаж байна. Энэ нь мэргэжлийн гэрэл зурагчдаас гадна гэрэл зургийн сэтгүүлчдийг бий болгож, цаашид хэвлэлийн гэрэл зураг жинхэнэ хөгжих хөрс суурийг тавьсан байна гэж үзэв.

Монголын гэрэл зургийн сэтгүүл нь 1956 оноос тодорхой системтэй хөгжих суурь тавигдсаныг харгалзан үзэж хөгжлийн хандлагыг тав хувааж үзэж болохоор байгаа бөгөөд цаашид нарийвчлан судалж, хөгжлийн үе бүрийн онцлог, давуу болон сул тал, хөгжлийн чиг хандлагыг судлах шаардлагатай байна.

Өнөөгийн нийгэмд гэрэл зураг нь технологийн хөгжлийн давуу талыг ашиглан улам бүр иргэдэд хялбар ойлгомжтой болж байгаа ч мэргэжлийн гэрэл зурагчид, тэр дундаа мэргэжлийн гэрэл зургийн сэтгүүлчид хэрэгтэй байгааг сүүлийн үеийн судалгаа баримтууд харуулж байна. Цаашид орчин үеийн технологи эзэмшсэн гэрэл зургийн сэтгүүлчдийн шинэ үеийг бэлтгэн гаргах нь манай салбарын тулгамдаж байгаа зорилтуудын нэг болсон нь бидний ажиглалтаас харагдаж байна.

Historical Development of Mongolian Press Photography

Batbaatar Tserendorj

Photojournalist, Doctoral student, Department of Journalism, Mongolian National University of Education Ulaanbaatar, Mongolia

Abstract: How long has press photography developed in Mongolia, some of the measures taken to develop it, how it has developed, and the current situation will be briefly discussed.

Having Mongolian photojournalists At the national level, it has been developing as a type of photojournalistic activity since the middle of 1940. Since then, the daily newspapers "Unen", "Höldölmör", "Zaluchuudyn Unen", "Pioneer's Unen", "Ulaanbaatar News", "Literature Art", "Ulaan Od", "Ekh orny Manaa" newspapers, "Modern Mongolia", "Science and life" magazine, State Photo and MONCAME agency have many photojournalists and photo reporters working. By the 1970s, the photography report type had been steadily developed and photographs, photo news, reports, and portraits taken by our first photographers were published regularly. Issue of phasing of the development of photojournalism in Mongolia. In this study, the development of Mongolian photography, especially the history of photojournalism is reviewed in phases as follows: The beginning of photojournalism in Mongolia - 1940 - early 1960s. The period of development of Mongolian professional photojournalism - from 1980 to 1990

Photojournalism of market and social transition period – 1990-2010,

From 2011 until now, as "Digital or modern photojournalism".

Thus, the photojournalism development can be reviewed in 5 phases.

We considered in addition to the development of photography technology, the time when professional photographers appeared.

As for today, the role of photography in the media is increasingly decorating the appearance of newspapers, and the quality of the information delivered to the readers is becoming a unique pattern.

Keywords: Photojournalism, historical photo, development of photography, digital or modern photojournalism

Ном зүй

- Lewis, G. (1995). *Photojournalism: content & technique*. California: USA.
- Дэлэг, Г. (1965). Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.
- Норовсүрэн, Л. (1982). *МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.
- Норовсүрэн, Л. (2012). *Фото сэтгүүл зүй*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Баасансүрэн, Т. (1985). *Монголд гэрэл зургийн алба үүсэж, хөгжсөн нь. товхимол*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.
- Монголын хэвлэлийн хүрээлэн, (2022). *Хэвлэлийн хүрээлэнгийн мониторинг судалгаа*. Улаанбаатар: Чөлөөт хэвлэл.